


小売業の安全衛生

Зурагт номоор ойлгох

Жижиглэн худалдааны аюулгүй байдал, эрүүл ахуй



Энэхүү дүрс бичлэгийн материалыг супермаркет гэх мэт жижиглэнгийн худалдаа эрхэлдэг бизнесийн байгууллагуудын ажилчдад аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсийг сурах зорилгоор бүтээсэн болно.



Өнөөдөр жижиглэн худалдааны салбарын аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сурцгаая!




Энэ бол бидний өдөр тутам хэрэглэдэг супермаркет, их дэлгүүрүүдийн танил орчин юм.

Тийм байна!



Ажиллаж байгаа нь зөвхөн дэлгүүрт байгаа хүмүүс биш юм.


Ар талд бас хүмүүс ажиллаж байдаг.



За, Хөдөлмөрийн осол гарч байгаа нөхцөл байдлыг авч үзье.

Тэгье!

Хөдөлмөрийн ослын гол шалтгааныг авч үзье.




Хөдөлмөрийн ослын тоо

1	Унах	36 %
2	Болгоомжгүй үйлдэл-Хүчлэх	13 %
3	Өндрөөс нисэх-Юмнаас унах	11 %
4	Зам тээврийн осол	11 %
5	Зүсэх / үрэхх	7 %

Лавлагаа: Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яам
 "2018 онд мэргэжлээс шалтгаалсан ослын тохиолдлын шинжилгээ / арилжааны (жижиглэнгийн худалдаа орно)"
 (2019 оны 5-р сар)



Унах осол их байх нь ээ.





Дараагийн хамгийн түгээмэл осол бол "Болгоомжгүй үйлдэл, хүчлэх" -с болж нурууны өвдөлт, үе мөчний өвдөлт юм. Хүнд ачаа тээш зөөхөд ийм гэмтэл авах нь амархан байдаг.

Ялангуяа нуруугаа 1 удаа гэмтээчихвэл сэдрэх нь амархан тул болгоомжтой байгаарай.



Хэрэв хүнд гэмтлийн улмаас ажиллаж чадахгүй бол гэр бүлийнхэн маань санаа зовж, орлого маань ч хүнд байдалд орох юм байна.



Тиймээс л гэмтэж бэртэхээс болгоомжлох хэрэгтэй.



"Өндрөөс нисэх-Юмнаас унах" осол нь дэлгүүрт бараа өрж байхад тохиолдох нь их байдаг.

Шат болон гишгүүрийг хэрхэн зөв ашиглахаа мэдэж байх хэрэгтэй.




"Зүсэх - үрэх" осол ч их гардаг уу?



Жишээлбэл ачааг задлах үед

Хутга болон цаасан хайрцагт гараа зүсэх тохиолдол байх тул иртэй зүйлтэй харьцахдаа болгоомжтой байх хэрэгтэй.

Аймар юм аа.




За тэгвэл




Бодит байдал дээр



харцгаая!

Тохиолдол 1







Ялангуяа бороотой өдөр шал халиргаатай болдог тул анхааралтай байхгүй бол болохгүй.

Хэрэв шал нь нойтон байвал ажиллахаасаа өмнө арчих хэрэгтэй.

Анхаарна аа.



Мөн манай дэлгүүрт савлууртай хаалга зүүн тал нь гарах бөгөөд хаалгыг удаанаар түлхэх дүрэмтэй байдаг шүү дээ?

Яарч байсан ч гүйж болохгүй.

Гүйгээгүй ш дээ...



Олон хүмүүс ар талд завгүй ажиллаж байдаг.

Багаж хэрэгсэл, бүтээгдэхүүн зэргийг тогтсон газарт байрлуулж байгаарай.

Хүн бүрийн ашигладаг газар тул 4S-г мөрдөж нямбай байх нь чухал.




За...



Сэтгэлээр унах хэрэггүй.

Дүрмийг дагаж мөрдөх нь хөдөлмөр эрхэлж буй хүн бүрийн аюулгүй байдлыг хангах явдал юм.

Энэ удаад өглөөний яриагаар хэлэх тул бүгдээрээ болгоомжтой байцгаая!



Сэнпай... Эелдэг юм аа!










Би хичээнэ ээ!





За за,

Хичээгээрэй.

Тохиолдол 2









Дээд тавцан дээр бүү гишгэ, дээрээсээ 2 дахь гишгүүр дээр гишгэж ажиллаарай.

NG

OK



Өндөр тавиур дээр ажиллахдаа гишгүүрийг зөв ашиглаарай.

Үүнийг ашиглахдаа тохирох өндөртэй гишгүүрийг сонгоод зөв байрлалд байрлуулна.

Тийм байх нь ээ.



Хэрэв анзаарсан бол эмх цэгцтэй байдал хэрэгтэй. 4S нь чухал юм.

Тиймээ.



Баярлалаа.




Хамгийн аюултай нь үүнд дасах юм.



За аа!

Тохиолдол 3





Хэцүү байгаа ч хурдлахгүй бол болохгүй.

Үгүй ээ, зүгээр!

Хөөе, бээлий өмсөөгүй байх чинь...

Яа...

Зүгээр үү !?



Тийм ч гүн зүсэгдээгүй юм шиг байгаа ч ...

Амралтын өрөөнд түр амрахгүй юу?



Уучилаарай






Амралтын өрөө


Зүсэлт нь том биш юм шиг байна.

Одоо зүгээр ээ.

Энэ удаа том асуудал гараагүй нь сайн боловч...
Биеийн байдал муу байгаа бол хүчлэлгүй, эхлээд мэдэгд.

Өнөөдрийнх шиг өндөр чийгшилтэй халуун өдрүүдэд халуунд цохиулах тохиолдол их байдаг.





Жижиглэн худалдааны салбарт анхаарах зүйлс





1 Нойтон шал, тосны толбоноос болгоомжил.



Ус, тос нь хальтиргаа гулгаа үүсгэдэг тул хальтардаггүй гутал өмсөөд 4S-ийг санаж яваарай.

2 Шатнаас унахаас болгоомжил.



Шат болон гишгүүрийг зөв ашигла.

3 Зүсэгчтэй харьцахдаа болгоомжтой байгаарай.



Зүсэгчийг өөрийн чиглэлд бүү байрлуул.

4 Халуун газар ажиллахдаа болгоомжтой байгаарай.



Байнга сэрүүн газар амарч, ус, давсаа сайн нөхөж байгаарай.

*Далгэрэнгүй мэдээллийг [Аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэс, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх (нийтлэг сургалтын хэрэглэгдэхүүн)].

Хөдөлмөрийн осол бол бусдын асуудал биш бидэнд ойрхон байдаг асуудал юм.



Дүрэм журмаа баримтлах нь “өөрийгөө”, “гэр бүл”, “амьдрал”-аа хамгаалж байна гэж санаж яваарай.

Хэрэв ямар нэг зүйл болвол
Өдөр бүрийн ажил дээрх харилцаа холбоо бас чухал юм.



За.
Дүрэм журмаа баримтлаж өдөр бүр хичээцгээе.



Жижиглэн худалдаа

Энэ тал дээр болгоомжтой байцгаая!

Аюулгүй байдал, эрүүл мэндийн талаархи зөвлөмжүүд!



1

Савлуур хаалгыг онгойлгох, хаах үед мөргөлдөхөөс болгоомжил!



2

Хүнд ачаа өргөхдөө зөв байрлал авах



3

Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдалд ч анхаарах



Ажлын байран дахь дүрмээ дагаж мөрдөцгөөе!



Ажлын байран дотор нуугдах аюулыг мэдэж авцгаая!

Аюулыг урьдчилан таамаглах сургалт (КҮТ)

Q Юу нь аюултай болохыг бодоорой!



A

Аюулын цэг!




1
Ачаа зөөх түрдэг тэрэг эсвэл ачаа зөөх дугуйт тэрэг ашиглахдаа арагш нь татах.



2
Цаасан хайрцгийг шалан дээр бүү тавь (4S).



3
Өвдөгөө нуглаж суун, өргөх хэрэгтэй.



Бусад аюултай цэгүүд байгаа эсэхийг бодоорой.

Зурагт номоор ойлгох Жижиглэн худалдааны аюулгүй байдал, эрүүл ахуй

2021 оны 3-р сарын хэвлэл
Хэвлүүлсэн: Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яам
Төлөвлөлт: Mizuho Information & Research Institute, Inc.
Хамтын ажиллагаа: Жижиглэн худалдааны салбартай холбоотой аюулгүй ажиллагааны боловсролын материал
Үйлдвэрлэл: Sideranch Inc.



Энэ материалтай холбоотой холбоо барих
Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яамны
Хөдөлмөрийн стандартын товчооны
Аюулгүй ажиллагааны хэлтэс,
Аюулгүй байдал, эрүүл ахуйн газар